



ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 6/64

Улаанбаатар хот

Б.Номиндарийг мэргэжилтэн /шинжээч/  
албан тушаалд томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг, 2019 оны Засгийн газрын "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай" 472 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны Оюуны өмчийн газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын хөтөлбөр, бүтцийг батлах тухай" А/123 дугаар тушаал, Авлигатай тэмцэх газрын 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 05/12036 тоот албан бичийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бумдорж овогтой Номиндарийг 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн Аж үйлдвэрийн өмчийн хэлтсийн Бүртгэлийн мэргэжилтэн албан тушаалаас чөлөөлж, 11 дүгээр сарын 02-ны өдрөөс Зохиогчийн эрхийн хэлтсийн Мэргэжилтэн /шинжээч/ албан тушаалд томилсугай.

2. Б.Номиндарийн ажлыг хүлээлгэн өгч, ажил хүлээлцсэн тухай тэмдэглэлийг 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Захиргаа удирдлагын хэлтэст ирүүлэхийг Хяналтын хэлтсийн дарга /Д.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

3. Б.Номиндарийн ажлыг зохих журмын дагуу тэмдэглэл үйлдэн 2020 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн дотор авахыг Аж үйлдвэрийн өмчийн хэлтсийн дарга /С.Урангэрэл/-д үүрэг болгосугай.

4. Б.Номиндарийн албан тушаалын цалинг төрийн захиргааны албан хаагч дэс түшмэл ангилал, ТЗ-7 зэрэглэлийн V шатлал тогтоож, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 10 хувь, төрийн захиргааны албан тушаалын дэс дүшмэлийн дөтгөөр зэргийн нэмэгдэл 18 хувь болон хоол, унааны нөхөн төлбөрийг холбогдох журмын дагуу тус тус тооцож олгохыг нягтлан бодогч /Э.Оюунцэцэг/-т зөвшөөрсүгэй.

ДАРГА

Б.ЭНХСҮХ



000817